


БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА



Б.АЛЕКСАНДР

**ЭМ, ОНОШЛУУР, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ХЭВЛҮҮЛЭХ ГЭРЭЭ, SP17050**

2017.11.13.136

2017.11.22

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эм, эмнэлгийн хэрэгслийн албаны дарга Г.Цэцэнсанаа /цаашид захиалагч тал гэх/, нөгөө талаас “Үндэсний үнэт цаас” ХХК - ийг төлөөлж Эдийн засагч Ч.Шинэтуяа /цаашид гүйцэтгэгч тал гэх/ нар Монгол улсын “Иргэний тухай”, “Үнэт цаасны тухай” хуулийн хүрээнд дараах зүйлийг харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Захиалагч талын эрх, үүрэг

2.1.1. Эмийн бүртгэлийн гэрчилгээ 500 ширхэг, оношлуурын гэрчилгээ 500 ширхэг, биологийн идэвхт бүтээгдэхүүний гэрчилгээ 500 ширхэг /цаашид гэрчилгээ гэх/ нийт 1500 ширхэг гэрчилгээг эх бэлтгэлийн загварын дагуу хэвлүүлнэ.

2.1.2. Захиалагч тал хэвлэгдэн гарсан гэрчилгээг ажлын 3 хоногт багтаан хүлээн авна.

2.1.3. Гэрчилгээний нэг бүрийн үнэ 1500 төгрөг байх бөгөөд нийт НӨАТ 10% - ийн хамт 1650 төгрөг буюу нийт 2475000 төгрөг (хоёр сая дөрвөн зуун далан таван мянган)-ийг “Үндэсний үнэт цаас” ХХК - ийн Голомт банк - 1102596741 тоот дансанд гэрчилгээг хэвлүүлэн хүлээн авснаар шилжүүлнэ.

2.2. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

2.2.1. Гүйцэтгэгч нь захиалсан гэрчилгээг эх бэлтгэлийн дагуу хэвлэнэ.

2.2.2. Бүтээгдэхүүний эх загварын бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.2.3. Гэрчилгээг нууцлал, чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.

2.2.4. Гүйцэтгэгч нь гэрчилгээний захиалсан загварыг буруу хэвлэсэн тохиолдолд учирсан хохиролыг өөрийн зардлаар нөхөн хэвлэнэ.

2.2.5. Гүйцэтгэгч гэрчилгээг захиалсан өдрөөс эхлэн ажлын 3 хоногт багтаан хэвлэж захиалагчид хүлээлгэн өгнө.

Гурав. Бусад

3.1. Талууд гэрээний нөхцлүүдийг зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.2. Гэрээний явцад үүссэн маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд эс зөвшөөрвөл хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

3.3. Гэрээг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрчилж, цуцалж, дуусгавар болгоно.

3.4. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

3.5. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:


Эрүүл мэндийн хөгжлийн төв

Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо

Энхтайваны гудамж 13/б

Эм, эмнэлгийн хэрэгсэлийн
албаны дарга

Утас: 70128804



"Үндэсний үнэт цаас" ХХК

Чингэлтэй дүүрэг 1-р хороо

Жуулчны гудамж 10/1

Эдийн засагч

Ч.Шинэтуяа

Утас: 327102, 312279